

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

**МҮОНР-ИЙН УРЛАГ СОЁЛЫН СЭДЭВТ НЭВТРҮҮЛГҮҮДИЙН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Б.Наранбаатар*, Д.Гэндэнсүрэн**

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D)

**МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үг: урлаг соёлын сэдэвт нэвтрүүлэг, радио, радио нэвтрүүлэг, редакци

Хүн төрөлхтний оюун ухааны хөгжлийн нэгэн том илрэл бол радио. XX зууны эхэн үед бий болсон радио нь “гэрэл цацрах”, “цацрах” гэсэн утгатай “radiare” гэсэн латин үгнээс үүсэлтэй. Манай улсад 1930-аад оноос эхлэн үндэс суурь нь тавигдсан радиогийн анхны өргөн нэвтрүүлэг 1934 оны есдүгээр сарын нэгний өдөр албан ёсоор цацагджээ.

Монголын Үндэсний Олон Нийтийн Радио /МҮОНР/-ийн нэвтрүүлгүүд дотор урлаг соёлын сэдэвт нэвтрүүлгүүд томоохон байр суурь эзэлдэг. Энэ сэдэвт нэвтрүүлгүүдийг тус радиогийн Урлаг соёлын редакци бэлтгэдэг. Эдгээр нэвтрүүлгүүд нь Монголын нийгмийн хөгжил, урлаг соёлын салбарт оруулсан хувь нэмэр, харилцан нөлөөллийг судлах, урлаг соёлын сэдэвт нэвтрүүлгүүдийг радиогоор дамжуулж сонсогчдод хүргэхдээ хэрхэн

зохицуулж ирсэн сэтгүүл зүйн арга хэлбэр, онцлогийг судлах хэрэгтэй юм.

Радио албан ёсоор өргөн нэвтрүүлгээ цацаж эхэлсэн цагаасаа дуу хөгжим, урлаг соёлын тоглолт, уран зохиолын төрөл зүйлээр бэлтгэсэн нэвтрүүлгүүдийг сонсогч олонд хүргэж байжээ. Энэ тухай “уран сайхны нэвтрүүлгийн төлөвлөгөө, программыг нэвтрүүлэгт оролцох хуваарьтай газрууд тус тусдаа хийж өөрсдийн удирдах газруудаар батлуулж ирдэг байлаа”¹ гэж анхны эмэгтэй нэвтрүүлэгч Л.Рагчаа дурсан ярьсан байна. Мөн эрдэмтэн зохиолч П. Хорлоо “С. Буяннэмэх бидний бичсэн шүлэг зохиолыг уншиж шалгаад, хэрэв болж бүтнэ гэвэл радиод уншуулдаг байв... 1934 оны арван хоёр дугаар сард Ц.Дамдинсүрэн... Д.Намдаг, Д.Нацагдорж... би хүртэл радиод очиж шүлгээ анх уншиж байлаа. С.Буяннэмэх гуай радиогоор шүлэг хэлэхдээ хуучраа дарж ая оруулаад, тэр аяныхаа дагуу шүлгээ

бичдэг, хэлдэг хүн байсан”² гэж радио үдэшлэгт орж байснаа дурсжээ.

Чухам энэ бүхэн нь Монголын радиогийн урлаг соёлын сэдэвт нэвтрүүлгийн эхлэл байсан гэж болох юм. Түүнээс хойш энэ бүх нэвтрүүлгүүд нь баяжиж, сэдэв агуулгын хувьд өргөжсөн нь манай улсад үндэсний соёл урлагийн газрууд байгуулагдаж, тэдгээр газрын гал голомтыг бадрааж явсан авъяас билигтнүүдтэй салшгүй холбоотой. Энэ нь 1935 онд алдарт дуучин М.Дугаржав нарын дуучид, хөгжимчид Москва хотод пянз, соронзон хальсанд бичүүлсэн дуу хуур, 1939 онд Соёлын ордон ба залуу театрын “Цэнд комиссар”, 1941 онд Улсын төв театрын баярын концерт ба “Гайхамшигт лимбэ” гэх дуулалт жүжгийг нэвтрүүлсэн зэргээс харагдана. Энэ бүх нэвтрүүлгүүд, жүжгүүд нь радиод урлаг соёлын алба нэгж бий болох үндсэн нөхцөл болжээ. Ямартай ч 1943 оны зургаа дугаар сарын 12 гэхэд радиод энэ алба, нэгж байгуулагдчихсан байсан тухай “.....уран сайхны хэрэг эрхлэх газрын утга зохиолын хэстэс, радио хорооны уран сайхны нэвтрүүлгийн редакци хамтран бүтэн өдрийн радио программыг цэрэг татлагад зориулжээ”³ гэж тэмдэглэсэн байна. Түүнээс хойш 1961 оны 4-р сарын 12-ны өдөр БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 163-р тогтоолоор Мэдээлэл, радио улсын хорооны программын хэлтэст харъяалуулж

– Жүжиг, уран зохиолын редакци

– Дуу хөгжмийн редакци нэртэйгээр бүтцийг баталснаар өнөөдрийн Монголын радиогийн урлаг соёлын сэдэвт нэвтрүүлгүүд бүрэлдэн хөгжихөд онцгой үүрэг гүйцэтгэжээ.

Тус хоёр редакци 2006 оноос нэгдэн “Урлаг соёлын редакци” болон ажиллаж байна. Редакцийн нэвтрүүлгийн бодлого, чиглэл нь олон нийтийн радио телевизийн хуулиар тодорхойлогдоно. Уг хуулийн хоёрдугаар бүлэгт

“...8.2.3.үндэсний соёл, урлаг, түүх, ёс заншил, уламжлалыг хүндэтгэх, үндэс-ний эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, хүрээлэн байгаа орчноо хамгаалахыг дэмжих;

8.2.5.соёл, урлагийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуйц уран бүтээлийн бүх хэлбэрийг дэлгэрүүлэн хөгжүүлэх”⁴ гэжхөтөлбөрийн бодлогыг тодорхойлсон.

Энэ тодорхойлолтын хүрээндсонсогч олонд түүх, ёс заншил, соёл уламжлал, утга зохиол, хөгжим, хэл соёл гэсэн сэдвийн хүрээнд шинэ мэдээ мэдээлэл хүргэх, асуудал дэвшүүлэх, танин мэдүүлэх, уламжлан хадгалах, соён гэгээрүүлэх, оюуны болон сэтгэлийн цэнгэл эдлэх, соёл урлагийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуйц нэвтрүүлгүүдийг радио сэтгүүл зүйн ихэнх төрлөөр бэлтгэж байна. Тэрчлэн хуулиар тодорхойлогдсон хөтөлбөрийн бодлогын хүрээнд дэлхийн соёлыг өөрийн орны сонсогчдод таниулах, өөрийн соёл уламжлал, урлагийг дэлхий нийтэд танин мэдүүлэх нэвтрүүлгүүд ч тусгагдсан болно. Радио бол нэг талаас хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нөгөө талаас урлаг билээ.

Монголын үндэсний олон нийтийн радиогийн урлаг соёлын сэдэвт нэвтрүүлгүүд

Монголын радио үүссэн цагаасаа эхлэн ардын аман зохиол, дуу хуур, эртний уран зохиол, ард түмний дунд

тархсан хөгжмийн зэмсэг, ая дан болоод шинэ тутам хөгжиж байгаа утга зохиолын төрөл, өөрийн болоод дэлхийн шилдэг хөгжмийн зохиолчдын бүтээлүүдийг урлаг соёлын сэдэвт нэвтрүүлгүүдээ түлхүү тусгаж ирсэн байна. Үүнээс гадна соёлын биет ба биет бус өв, зан үйл, ёс уламжлал гэх мэтээс гадна урлаг, соёлын байгууллагын зүтгэлтнүүдийг ч тусгажээ. Энэ нь 1954 онд үндэслэгдэж өнөөг хүртэл ажиллаж байгаа “Алтан сан”-д хадгалагдаж байгаа радио бүтээлүүдээс харагдана. Тухайлбал алтан санд хадагалагдаж байгаа уран зохиолын төрлөөр хийсэн уран бүтээлүүдийн тоог ангилбал үлгэр 1100, жүжиг 449, уран зохиолын бусад төрлөөр 1500 хадгаламжийн нэгж бүтээлүүд байна.

МҮОНР-ийн урлаг соёлын сэдэвт зарим нэвтрүүлгүүдийн тухай судлаачид, сэтгүүлчид бүтээл туурьвилдаа дурдсан байдаг. Урлаг судлаач, доктор Дэ. Мягмарсүрэн “...ардын ерөөл, магтаал нь радиогийн гоо зүйн онцлогийг хадгалснаараа радиод тун зохицсон уран сайхны анхны бүтээлийн нэг юм. Юуны өмнө хүмүүст хандаж хүүрнэн өгүүлэх ерөөлч нь сонсогчтой ер бусын дотны харьцаагаар холбогдож, түүнийг гэртээ байгаа мэтээр уран уншлагыг нь амтархан сонсдог ажээ. 1952 онд алдарт ерөөлч Тэрбишийн ерөөл, магтаалуудыг радиогоор нэвтрүүлж, алтан фондонд хадгалсан нь үүний гэрч юм”⁵ гэсэн нь аман зохиолын төрөл зүйлээр бэлтгэсэн нэвтрүүлэг радиод хэрхэн зохицдогийг хэлж байна.

Урлаг соёлын сэдэвт нэвтрүүлгүүд нь цаг ямагт сэдэв агуулга, хэлбэр хийцийн төрөлд шинэчлэгдэн хөгжсөөр өнөөдрийг хүрсэн. Энэ тухай судлаач Л.Амарзаяа “Радио жүжиг” бүтээлдээ

радио уран сайхны нэвтрүүлэг, радио жүжгийн бүтээлийн төлөвшил онцлогийг

1. Радиогийн шууд нэвтрүүлгийн үе 1934-1950 он
2. Радио зохиомжийн үе 1950-1970 он
3. Радио зохиомж, жүжигчилсэн зохиомж хосолсон үе 1970-1990 он
4. Радио жүжгийн хөгжлийн үе 1990-ээд оноос хойшхи гэж ангилснаас харагдана.

МҮОНР-ийн Урлаг соёлын редакци уран сайхны сэдэвт нэвтрүүлгийг голлон бэлтгэж хүргэдгээрээ онцлог бөгөөд одоо дараах нэвтрүүлгүүдийг бичлэгээр бэлтгэн хүргэж байна.

“Найраг хөгжөөх цаг”. Монголын нэрт яруу найрагчдын болон залуу залгамж үеийнхний шинэ, онцгой содон яруу найргийг өөрсдийнх нь дуу хоолойгоор хүргэдэг нэвтрүүлэг. 1934 оны 12 дугаар сард болсон радио үдэшлэгээс үүсэлтэй гэж үзэж болно. Хугацаа 20 минут. Сард нэг удаа нэвтрүүлдэг.

“Дэлхийн уран зохиол”. Социалист нийгмийн үед холбоотон орны уран зохиолыг таниулах зорилгоор эхэлжээ. Бодлогын хувьд нийгмийн хөгжлийг даган өөрчлөгдөж ирсэн. 2015 онд бодлогын хувьд эрс өөрчилж дэлхийн сонгодог зохиолчдын шилдэг, шинэ зохиолыг монголчууддаа хүргэх бодлогыг баримталж байна. Хугацаа 20 минут. Сард нэг удаа нэвтрүүлдэг.

“Ардын хөгжмийн сан”. Ардын уламжлалт дуу хуур, бүжиг соёлтой холбоотой ёс заншил, түүх домог, ардын авьяастнуудын дуулах, бүжиглэх, хөгжимдөх арга барилын тухай тайлбарлан хүргэдэг нэвтрүүлэг. Хугацаа 25 минут. Сард хоёр удаа нэвтрүүлдэг.

“Сонгодог хөгжмийн сан”.

Дэлхийн болон өөрийн орны сонгодог бүтээл, сонгодог урлагийн бүтээлчдийн тухай хөгжмийн боловсролд зориулсан тайлбарт нэвтрүүлэг. Хугацаа 20 минут. Сард хоёр удаа нэвтрүүлдэг.

“Дуун увидас”. Олон арван жилээр хүмүүсийн сэтгэлд хоногшсон дууны тухай тайлбарт, танин мэдэхүйн нэвтрүүлэг. 2015 оноос нэвтрүүлж эхэлсэн. Хугацаа 40 минут. Сард хоёр удаа нэвтрүүлдэг.

“Хөгжмийн хайрцаг”. Хүүхдийн боловсролд зориулсан хөгжмийн нэвтрүүлэг. Хугацаа 15 минут. Сард дөрвөн удаа нэвтрүүлдэг.

“Дэлхийн хүмүүс”. Дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн бүх салбарынгайхамшигт хүмүүсийн аж амьдрал, түүхэн замналын тухай хөрөг нэвтрүүлэг. 1974 онд “Суут хүмүүс” нэрээр социалист нийгмийн удирдагчдыг магтан дуулах, таниулах зорилгоор бэлтгэн эхэлж байсан. Хугацаа 20 минут. Сард хоёр удаа нэвтрүүлдэг.

“Алтан цадиг”. Монголын түүхийн тайлбарт, уран сайхны нэвтрүүлэг. 2006 онд Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулан бэлтгэж эхэлсэн. Хугацаа 20 минут. Сард дөрвөн удаа нэвтрүүлдэг.

“Уран зохиол”. Монголын орчин үеийн утга зохиолын шилдэг

өгүүллэг, туурь, дууль... зэрэг олон жанрыг радиод зохицуулан зохиомжилж хүргэ-дэг. Хугацаа 20 минут. Сард хоёр удаа нэвтрүүлдэг.

“Их хөлгөн туульс”. Монголын шилдэг романуудыг уран уншлагаар хүргэдэг. “Монголын нууц товчоо”, “Хөх судар” тэргүүт олон романыг хүргээд байна. Хугацаа 15 минут. Сард 12 удаа нэвтрүүлдэг.

“Саран хөхөө” радио театр. Радио жүжгийн төрлөөс гадна дэлгэцийн бүтээлүүд, уран зохиолын төрөл зүйлийг радиод зохицуулан зохиомжилж хүргэдэг. 1939 онд Соёлын ордон ба залуу театрын “Цэнд комиссар” дуулалт жүжгээс үүсэлтэй гэж үзэж болно. Хугацаа 60 минут. Сард нэг удаа нэвтрүүлдэг.

МУОНР-ийн урлаг соёлын нэвтрүүлгийн ихэнх хувийг хөгжим, уран зохиолын сэдэвт нэвтрүүлгүүд эзэлж байна. Энэ нь радиогийн өөрийн

мөн чанарт илүү тохирч, хөгжилд нь онцгой хувь нэмэр оруулсан. Түүнээс гадна энэ сэдэвт нэвтрүүлгүүд нь сэтгүүл зүйд “Радиогийн уран сайхны сэдэвт нэвтрүүлгүүд” гэх сэтгүүлзүйн нэгэн бичлэгийн төрлийг бий болгожээ.

Ишлэл

- 1 Бадамдож Д., Шаравдож Н. 1994. Миний радио. УБ., 3-р тал
- 2 Баярсайхан Б. 2014. Хөх тэнгэрийн радио. УБ., 26-р тал

- ³ Бадамдож Д., Шаравдож Н. 1994. Миний радио. УБ., 11-р тал
- ⁴ Олон нийтийн радио, телевизийн тухай хууль. 2005 //http://www.legalinfo.mn
- ⁵ Чойжил М.2004. Чихнээ сонсголт радио хэмээх тэмдэглэл. УБ., 6-р тал

4. Чойжил М. Чихнээ сонсголт радио хэмээх тэмдэглэл. УБ.,2004
5. МҮОНР-н Алтан сан хадгаламжийн нэгжийн бүртгэл
6. <http://www.legalinfo.mn>

Резюме

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Амарзаяа Л. Радио жүжиг. УБ.,2006
2. Бадамдож Д., Шаравдож Н. Миний радио. УБ., 1994
3. Баярсайхан Б. Хөх тэнгэрийн радио. УБ., 2014

Данная статья посвящена теме о передачах об искусстве и культуре на Общественном радио Монголии. Авторы уделяют большое внимание историческим этапам становления данной тематики на Монгольском радио, жанровым особенностям радиопередач и современной потребности слушателей.